



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/285

Алтай хот

Гамшгийн сангаас хөрөнгө
зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Гамшгийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам, аймгийн Онцгой комиссын 2022 оны 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шарга сум дахь аймгийн аюулгүйн нөөцийн 1 дүгээр агуулах засварлах зардал, 2022 онд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны ажлын зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 7,000,000 (долоон сая) төгрөгийг аймгийн Гамшгийн сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн засаг даргын
2022 оны 05 дугаар сарын 13 -ны өдрийн
1685 дугаар захирамжийн хавсралт



ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Зардлын хэмжээ /төгрөг/
1	Шарга сум дахь аймгийн аюулгүйн нөөцийн 1 дүгээр агуулах засварлах зардал	3,000,000
2	2022 онд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааны ажлын зардал	4,000,000
	НИЙТ	7,000,000

__оОо__